



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-н
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/10/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.08.15 № 4-6/395

танай _____-ны № _____-т

ХАМАРЫН ХИЙДИЙН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ЗАХИРГАА ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ш.БАЙГАЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр тус байгууллага нь 2021 оны 12-р сард АИТХ-ын тэргүүлэгчдийн 57 тоот тогтоолоор ОНӨААТҮГ статустайгаар байгуулагдсан, тус тогтоолын 01 дүгээр хавсралтын ОНӨААТҮГ-ын дүрэм дэх 6 дугаар заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдсан ч уг ТУЗ нь огт хуралдаагүй, бизнес төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшнийг тодорхойлоогүй, батлаагүй байна. Энэ нь ТБОНӨТухай хуулийн 20 дугаар зүйл "Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг"-ийн "Зүйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" 21 дүгээр зүйл "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог"-ийн "14.Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуульд заасан тайлан, бусад мэдээллийг

012059472

холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.", заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй, Сангийн сайдын баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэж, төсөвт байгууллагад ашиглагддаг CTS санхүүгийн программыг ашиглан тайлангаа гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл "Нягтлан бодох бүртгэлийн стандарт"-ийн 4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө, 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-тай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Байгууллагын дотоод хяналт хийх журам, мөнгөн кассын ажиллагааны журам боловсруулж ажиллаагүй байна. Энэ нь ТБОНӨТухай хуулийн 67 дугаар зүйл "Дотоодын хяналт шалгалт"-ын "1.Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна., 2.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна." заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Тус байгууллага нь үйл ажиллагаа эхэлснээс хойш байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт"-ийн "18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20 дугаар зүйл."Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг"-ийн "20.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллага нь шилэн дансны цахим системд бүртгүүлээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл "Хуулийн үйлчлэх хүрээ"-ийн 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, тасалбар болголт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 7.4 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Авлага, өглөгийн тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12-р зүйл "12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг

дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 зорилт, 22 арга хэмжээний хэрэгжилт 81.8 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	14,154,525.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	3,100,842.11
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	3,000.00
31110	Төгрөг	-	3,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	3,097,842.11
3121	Төгрөг	-	3,097,842.11
31211	Төрийн сангийн харилцах	-	3,097,842.11
33	АВЛАГА	-	965,857.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	182,770.38
335	Бусад авлага	-	783,087.00
3351	Байгууллагаас авах авлага	-	220,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	563,087.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	10,087,826.00
354	Хангамжийн материал	-	10,087,826.00
35410	Бичиг хэргийн материал	-	685,600.00
35420	Аж ахуйн материал	-	8,020,910.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,375,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	6,316.00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	-	209,352,377.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	209,352,377.98
392	Биет хөрөнгө	-	207,812,377.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	107,846,082.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,034,452.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	22,208,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,370,510.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	15,852,208.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,318,600.61)
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	(24,612,221.59)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	48,695,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	132,101,822.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(77,555,349.61)
393	Биет бүс хөрөнгө	-	1,540,000.00
39301	Програм хангамж	-	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(110,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	223,506,903.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,000.00
413	Өглөг	-	3,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	223,503,903.47
51	Засгийн газрын хувь оролцоо	-	223,503,903.47
512	Хуримтлагдсан үр дүн	-	223,503,903.47
51220	Тайлант үеийн үр дүн	-	223,503,903.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	223,506,903.47

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	402,017,764.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	268,588,964.14
120	Нийтлэг татварын бус орлого	-	258,588,964.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	258,588,964.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	62,224,010.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	196,364,954.14
122	Тусламжийн орлого	-	10,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	133,428,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,428,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,428,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	120,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	120,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	185,937,070.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	185,937,070.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	185,937,070.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	120,351,555.97
210101	Үндсэн цалин	-	106,211,555.97
210102	Нэмэгдэл	-	14,140,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	14,208,610.74
210201	Тэтгэврийн даатгал	-	14,208,610.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	811,104.00
210301	Гэрэл, цахилгаан	-	811,104.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	13,923,874.00
210401	Бичиг хэрэг	-	886,650.00
210402	Тээвэр, шатахуун	-	11,843,684.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,193,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,641,540.00
210604	Урсгал засвар	-	3,641,540.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,268,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,268,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	14,080,542.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	14,014,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	8,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	-	24,892.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,651,843.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	19,067.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	16,632,776.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	216,080,693.47
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	7,490,710.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	7,490,710.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	67,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	67,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	7,423,210.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	223,503,903.47

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D08	Тайлант үеийн үр дүн	223,503,903.47	223,503,903.47
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	223,503,903.47	223,503,903.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	192,227,010.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	72,227,010.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	62,227,010.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	62,227,010.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	62,227,010.00
122	Тусламжийн орлого	-	10,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	120,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	120,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	120,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	172,934,767.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	172,934,767.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	172,934,767.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	123,127,102.00
210101	Үндсэн цалин	-	123,127,102.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	12,674,922.09
210201	Тэтгэврийн даатгал	-	12,674,922.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	811,104.00
210301	Гэрэл, цахилгаан	-	811,104.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	14,639,790.00
210401	Бичиг хэрэг	-	1,746,250.00
210402	Тээвэр, шатахуун	-	11,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,043,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,414,240.00
210604	Урсгал засвар	-	5,414,240.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,268,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,268,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	13,980,542.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	13,914,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	8,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	-	24,892.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	19,067.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	19,067.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	19,292,242.11
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	16,191,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,191,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,191,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	16,191,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(16,191,400.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	3,100,842.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,100,842.11

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39.7 сая төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад 39.7 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Шатахууны 0.3 сая төгрөгийн хөнгөлөлтийг бүртгээгүй байсныг залруулсан.
2. 1.1 сая төгрөгийн ХХОАТ-ын авлагыг санхүүгийн тайланд бүртгээгүй байсныг залруулсан.
3. Элэгдлийн зардлыг 2.1 сая төгрөгөөр дутуу тооцсоныг залруулсан.
4. Балансаас баланст 26.7 сая төгрөгийг үлдэгдэл өртөгтэй Фургон авто машиныг бүртгээгүй орхигдуулсныг, 1.1 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг “0” үлдэгдэлтэйгээр бүртгэснийг залруулсан.
5. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын 0.9 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгээгүй байсныг залруулсан.
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан 7.5 сая төгрөгийн бараа материалыг үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 7 зөрчил² илэрснээс 6 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Авлага, өглөгийн тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах, бодитой мэдээллээр хангагдахгүй байх үр дагавартай. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12-р зүйл “12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Байгууллагын хариуцлагын хэлбэртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2021 оны 12-р сард АИТХ-ын тэргүүлэгчдийн 57 тоот тогтоолоор ОНӨААТҮГ статустайгаар байгуулагдсан, тус тогтоолын 01 дүгээр хавсралтын ОНӨААТҮГ-ын дүрэм дэх 6 дугаар заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдсан ч уг ТУЗ нь огт хуралдаагүй, бизнес төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшнийг тодорхойлоогүй, батлаагүй байна. Энэ нь бодит мэдээллээр хангагдахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

ТБОНӨТухай хуулийн 20 дугаар зүйл “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг”-ийн “3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;” 21 дүгээр зүйл “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог”-ийн “14.Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуульд заасан тайлан, бусад мэдээллийг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.”, заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй, Сангийн сайдын баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэж, төсөвт байгууллагад ашиглагддаг СТС санхүүгийн программыг ашиглан тайлангаа гаргасан байна. Энэ нь хууль хэрэгжихгүй байх, стандарт мөрдөгдөхгүй байх үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ийн 4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мөрдөнө, 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-тай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын тушаалыг мөрдөж хэрэгжүүлж ажиллах, батлагдсан маягтын дагуу санхүүгийн тайланг гаргах, СТОУС-ыг мөрдөх

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналт хийх журам, мөнгөн кассын ажиллагааны журам боловсруулж ажиллаагүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө дутагдах, зориулалт бусаар зарцуулагдах үр дагавартай.

ТБОНӨТухай хуулийн 67 дугаар зүйл “Дотоодын хяналт шалгалт”-н “1.Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна., 2.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.” заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх журам, мөнгөн кассын ажиллагааны журам боловсруулж батлан мөрдөж ажиллах

4. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:Тус байгууллага нь үйл ажиллагаа эхэлснээс хойш байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй байна. Энэ нь хууль хэрэгжихгүй байх, нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөгдөхгүй байх үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт”-ийн “18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”, 20 дугаар зүйл.”Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”-ийн “20.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;” заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын НБББББ-н боловсруулж батлан, мөрдөж ажиллах

5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь шилэн дансны цахим системд бүртгүүлээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл “Хуулийн үйлчлэх хүрээ”-ийн 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, тасалбар болголт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд бүртгүүлж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

6. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 7.4 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар

татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтүүдийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Шатахууны 0.3 сая төгрөгийн хөнгөлөлтийг бүртгээгүй байсныг залруулсан	1	285.0			1	285.0	1	285.0				
1.1 сая төгрөгийн ХХОАТ-ын авлагыг санхүүгийн тайланд бүртгээгүй байсныг залруулсан	1	1,099.1			1	1,099.1	1	1,099.1				
Элэгдлийн зардлыг 2.1 сая төгрөгөөр дутуу тооцсоныг залруулсан.	1	2,093.2			1	2,093.2	1	2,093.2				
Балансаас балансад 26.7 сая төгрөгийг үлдэгдэл өртөгтэй Фургон авто машиныг бүртгээгүй орхигдуулсаныг, 1.1 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг “0” үлдэгдэлтэйгээр бүртгэснийг залруулсан	1	27,809.7			1	27,809.7	1	27,809.7				
Аж ахуй нэгжийн орлогын албан татварын 0.9 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгээгүй байсныг залруулсан	1	952.5			1	952.5	1	952.5				
Үнэ төлбөргүй хүлээн авсан 7.5 сая төгрөгийн бараа материалыг үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй байсныг залруулсан	1	7,490.7			1	7,490.7	1	7,490.7				
Дүн	6	39,730.2			6	39,730.2	6	39,730.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь 2021 оны 12-р сард АИТХ-ын тэргүүлэгчдийн 57 тоот тогтоолоор ОНӨААТҮГ статустайгаар байгуулагдсан, тус тогтоолын 01 дүгээр хавсралтын ОНӨААТҮГ-ын дүрэм дэх 6 дугаар заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдсан ч уг ТУЗ нь огт хуралдаагүй, бизнес төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшнийг тодорхойлоогүй, батлаагүй байна.	1						1					
Байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй, Сангийн сайдын баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэж, төсөвт байгууллагад ашиглагддаг CTS санхүүгийн программыг ашиглан тайлангаа гаргасан байна.	1						1					
Байгууллагын дотоод хяналт хийх журам, мөнгөн кассын ажиллагааны журам боловсруулж ажиллаагүй байна.	1						1					
Тус байгууллага нь үйл ажиллагаа эхэлснээс хойш байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй байна.	1						1					
Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 7.4 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1						1					
Авлага, өглөгийн тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.	1				1							
Дүн	6				1		5					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллага нь шилэн дансны цахим системд бүртгүүлээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна.	1		-	-		-	1	
Дүн	1		-	-		-	1	